



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/217/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг:zayag@audit.gov.mn
Аудитор:Ц.Алтантуул
Утас: 91195554
Цахим хаяг : tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.21 № 1202/80
танай _____ -ны № _____ -т

ХӨГЖИМТ ЖҮЖГИЙН
ТЕАТРЫН ДАРГА Г.СОЛОНГО
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжимт жүжгийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013022983

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	212,019.2	258,028.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,288.4
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	2,288.4
31110	Төгрөг	-	288.4
31130	Нэмэлт санхүүжилт	-	2,000.0
33	АВЛАГА	1,092.5	852.5
335	Бусад авлага	1,092.5	852.5
3351	Байгууллагаас авах авлага	612.5	592.5
3352	Хувь хүмүүсээс авах авлага	480.0	260.0
35	БАРАА МАТЕРИАЛ	210,926.7	254,887.2
351	Түүхий эд материал	55,110.3	72,374.3
35110	Тусгай зориулалттай материал	55,110.3	72,374.3
35300	Бэлэн бүтээгдэхүүн	730.1	608.8
354	Хангамжийн материал	154,665.3	181,584.2
35410	Бичиг хэргийн материал	562.3	484.4
35420	Аж ахуйн материал	1,491.0	1,302.4
35450	Барилгын засварын материал	2,378.0	1,833.8
35470	Бусад хангамжийн материал	150,234.0	177,963.6
35600	Мал амьтад	421.0	320.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	727,379.4	629,981.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	727,379.4	629,981.5
392	Биет хөрөнгө	691,759.4	594,361.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	451,792.0	451,792.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(112,948.0)	(169,422.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	913.9	913.9
39204	Хуримтлагдсан элэгдэл	(913.9)	(913.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	358,723.0	358,723.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(196,555.5)	(236,280.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,070.6	89,070.6
39208	Хуримтлагдсан элэгдэл	(80,125.4)	(81,324.2)
39214	Бусад үндсэн хөрөнгө	182,531.7	182,531.7
39215	Хуримтлагдсан элэгдэл	(729.1)	(729.1)
393	Биет бус хөрөнгө	35,620.0	35,620.0
39303	Бусад биет бус хөрөнгө	36,390.0	36,390.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	(770.0)	(770.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	939,398.6	888,009.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	930,898.6	888,009.6
51	Засгийн газрын хувь оролцоо	930,898.6	888,009.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	711,463.3	711,463.3

51101	Өмч: - төрийн	711,463.3	711,463.3
512	Хуримтлагдсан үр дүн	(182,386.3)	(225,275.3)
51210	Өмнөх үеийн үр дүн	(182,386.3)	(182,386.3)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(42,889.0)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	401,821.7	401,821.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	939,398.6	888,009.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,088,487.33	957,479.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	174,430.83	1,527.00
120	Нийтлэг татварын бус орлого	174,430.83	1,527.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	171,847.01	1,527.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,970.26	1,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	150,666.75	227.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	914,056.50	955,952.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,658.80	924,026.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,658.80	924,026.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	31,926.51
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	31,926.51
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	995,931.25	1,000,040.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	995,931.25	1,000,040.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	945,172.75	897,730.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,117.75	529,613.35
210101	Үндсэн цалин	459,034.23	392,073.27
210102	Нэмэгдэл	74,239.05	105,308.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,844.47	32,232.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,864.60	70,369.68
210201	Тэтгэврийн даатгал	54,544.08	49,061.65
210202	Тэтгэмжийн даатгал	5,646.97	5,404.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,802.72	4,256.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178.85	1,041.57
210205	Эрүүл мэндийн даатгал	11,691.98	10,605.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,522.37	175,586.10
210301	Гэрэл, цахилгаан	6,973.01	6,942.03
210302	Түлш, халаалт	159,500.00	159,500.00
210303	Цэвэр, бохир ус	8,049.36	9,144.07
2104	Хангамж, бараа материалын зардал	3,431.92	5,397.65

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	977.20	874.40
210402	Тээвэр, шатахуун	1,529.90	1,364.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	924.82	605.20
210408	Бараа материал акталсны зардал	-	2,553.15
2105	Нормативт зардал	908.60	632.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	908.60	632.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,652.21	5,460.87
210601	Багаж, техник, хэрэгсэл	570.71	3,172.85
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	480.00	200.00
210604	Урсгал засвар	2,601.50	2,088.02
2107	Томилолт, зочны зардал	1,079.30	1,082.00
210702	Дотоод албан томилолт	1,079.30	1,082.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,101.07	5,397.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,540.09	4,072.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864.00	806.40
210807	Газрын төлбөр	320.58	320.58
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	376.40	198.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,494.93	104,191.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,793.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,494.93	97,397.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,758.50	102,310.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,825.20	50,997.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,484.80	46,497.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340.40	4,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,996.79	51,312.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,996.79	51,312.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	92,556.08	(42,561.01)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	160.00	328.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	160.00	328.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(160.00)	(328.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	92,396.08	(42,889.01)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх	711,463.26	401,821.67	(274,782.40)	838,502.52

	үлдэгдэл				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	711,463.26	401,821.67	(274,782.40)	838,502.52
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	92,396.08	92,396.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,463.26	401,821.67	(182,386.33)	930,898.60
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	711,463.26	401,821.67	(182,386.33)	930,898.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	711,463.26	401,821.67	(182,386.33)	930,898.60
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(42,889.01)	(42,889.01)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	711,463.26	401,821.67	(225,275.33)	888,009.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	937,340.58	957,472.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,284.08	1,520.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,284.08	1,520.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,700.26	1,520.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,490.26	1,520.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	914,056.50	955,952.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,658.80	924,026.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,658.80	924,026.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	31,926.51
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	31,926.51
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	937,340.58	955,184.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,340.58	955,184.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,582.08	852,874.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,730.24	529,593.36
210101	Үндсэн цалин	459,646.72	392,053.28
210102	Нэмэгдэл	74,239.05	105,308.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,844.47	32,232.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,764.60	70,369.68
210201	Тэтгэврийн даатгал	54,444.08	49,061.65

210202	Тэтгэмжийн даатгал	5,646.97	5,404.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,802.72	4,256.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178.85	1,041.57
210205	Эрүүл мэндийн даатгал	11,691.98	10,605.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174,672.17	175,586.10
210301	Гэрэл, цахилгаан	7,048.01	6,942.03
210302	Түлш, халаалт	159,500.00	159,500.00
210303	Цэвэр, бохир ус	8,124.16	9,144.07
2104	Хангамж, бараа материалын зардал	3,796.42	2,789.80
210401	Бичиг хэрэг	1,177.90	819.70
210402	Тээвэр, шатахуун	1,529.90	1,364.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,088.62	605.20
2105	Нормативт зардал	929.00	929.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	929.00	929.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,093.40	5,853.62
210601	Багаж, техник, хэрэгсэл	717.90	3,430.60
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	568.00	300.00
210604	Урсгал засвар	2,807.50	2,123.02
2107	Томилолт, зочны зардал	1,079.30	1,082.00
210702	Дотоод албан томилолт	1,079.30	1,082.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,516.95	38,224.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,955.97	36,899.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864.00	806.40
210807	Газрын төлбөр	320.58	320.58
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	376.40	198.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,446.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,446.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,758.50	102,310.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,825.20	50,997.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,484.80	46,497.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	340.40	4,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,996.79	51,312.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,996.79	51,312.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	2,288.40
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,288.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,288.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924,026.20	872,713.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,028.40	821,716.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	586,818.10	529,593.36
210101	Үндсэн цалин	450,500.40	392,053.28
210102	Нэмэгдэл	90,957.70	105,308.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,360.00	32,232.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,220.40	70,369.68
210201	Тэтгэврийн даатгал	55,747.70	49,061.65
210202	Тэтгэмжийн даатгал	5,868.20	5,404.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,694.50	4,256.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,173.60	1,041.57
210205	Эрүүл мэндийн даатгал	11,736.40	10,605.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,586.10	175,586.10
210301	Гэрэл, цахилгаан	11,942.80	6,942.03
210302	Түлш, халаалт	154,352.10	159,500.00
210303	Цэвэр, бохир ус	9,291.20	9,144.07
2104	Хангамж, бараа материалын зардал	2789.8	2789.8
210401	Бичиг хэрэг	819.7	819.7
210402	Тээвэр, шатахуун	1364.9	1364.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	605.2	605.2
2105	Нормативт зардал	929	929
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	929	929
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2854.4	2853.624
210601	Багаж, техник, хэрэгсэл	430.6	430.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300	300
210604	Урсгал засвар	2123.8	2123.024
2107	Томилолт, зочны зардал	1082	1082
210702	Дотоод албан томилолт	1082	1082
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27748.6	38512.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25899.2	36899.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864	806.4
210803	Даатгалын үйлчилгээ	128.4	128.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70	70

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90	90
210807	Газрын төлбөр	320.6	320.58
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	376.4	198
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46.9978	50.9978
2132	Бусад урсгал шилжүүлэг	46997.8	50997.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46497.8	46497.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500	4500
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	924026.2	924026.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	924026.2	924026.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	924026.2	924026.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	288.4
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60.00	60.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	49.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,446.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ		31,446.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		31,446.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		28,446.51
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	31.93
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		31,926.51
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		31,926.51

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөгжимт жүжгийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөгжимт жүжгийн театр нь ардын уламжлалт зан заншил, соёл урлагаа, дэлхийн сонгодог урлагтай хослуулан хөгжүүлж, иргэдийн оюун санааны хөгжлийг тэтгэхэд оршино. Хөгжимт жүжгийн театр нь иргэдэд соёл урлагаар үйлчлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжимт жүжгийн театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт зардлын 496.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 1,000.0 сая төгрөгийн 1.5 хувь буюу 15.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 75 хувь буюу 11.3 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	1,092.5	852.5	240.00
Бараа материал	210,926.7	254,887.2	(43,960.45)
Үндсэн хөрөнгө	727,379.4	629,981.5	97,397.86
Өр төлбөр	8500.0	0	8500.0
Засгийн газрын хувь оролцоо	930,898.6	888,009.6	42,889.01
Өр төлбөр эздийн өмчийн дүн	939,398.6	888,009.6	51,389.01

Авлага дансны үлдэгдэл 240.0 мянган төгрөгөөр буурсан нь авлага барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 43,960.4 мянган төгрөгөөр өссөн нь Жангар жүжигт зориулан хувцас, хэрэглэл бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 97,397.8 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөрийн данс 8,500.0 мянган төгрөгөөр буурсан нь өрөө төлж барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 42,889.0 мянган төгрөгөөр болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 924,026.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 924,026.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 924,026.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 872,713.9 мянган төгрөгийг зарцуулж, 51,312.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Жангар жүжигтэй холбоотой 31,926.5 мянган төгрөгийн, өөрийн үйл ажиллагааны хүрээнд 1,520.0 мянган төгрөгийн, нийт 33,446.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрүүлсэн байна.

Нэмэлт орлогоос бараа үйлчилгээний бусад зардалд 31,446.5 мянган төгрөгийг зарцуулж 2,000.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Ажилчдын илүү цагийг журмын дагуу бодоогүй, төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн үйл ажиллагааны журмыг баримтлан ажиллаагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагад ашиглагдаж байгаа хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө 8.7 сая төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээний тайланг журмын дагуу бэлтгэн гаргаагүй байсныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Ажилтнуудад 7.6 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд заасныг баримтлаагүй, илүү тооцож олгосон тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Тэмцээнд оролцсон ажилтнуудын шагналд олгосон 2.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулах үүргийг албан шаардлага хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Хөгжимт жүжгийн театр	4	18.3	2	8.7	1	7.6	1	2.0		